

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2024 оны 03 сарын 04 өдөр

№ 24/003

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Тооллогын комисс томилох тухай

“Мандал Ирээдүйн Өсөлт ХОС” ХХК-ийн 2024 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдахтай холбоотойгоор Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Мандал Ирээдүйн Өсөлт ХОС” ХХК-ийн 2024 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй **БАЙГУУЛСУГАЙ.**

- 1.1. Комиссын дарга: Г.Тулга /санхүүгийн хариуцсан захирал/
1.2. Гишүүд: С.Дашзэвэг /ахлах менежер/
У.Сансармаа /ахлах хуульч/
Н.Болор-Эрдэнэ /хөрөнгө оруулалтын ахлах шинжээч/
Б.Энхтуул /хөрөнгө оруулалтын шинжээч/

2. Тооллогын комиссын дарга /Г.Тулга/-д дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг **ДААЛГАСУГАЙ.** Үүнд:

- 2.1 Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
2.2 Нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултад тайлбар өгөх;
2.3 Санал өгөх журмыг тайлбарлах, нэгж эрх эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
2.4 Саналын хуудсыг тоолж, саналын хуудсыг хүлээн авах бөгөөд санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэл хөтлөх;
2.5 Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг нэгж эрх эзэмшигчдийн хуралд танилцуулах;
2.6 Саналын хуудсыг сангийн архивд хадгалуулахаар шилжүүлэхийг тус тус үүрэг **БОЛГОСУГАЙ.**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

